



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/ЗНТ

Улаанбаатар хот

Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол Улсын
элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээтэй
дүйцүүлэн тооцох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 59.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн, улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын оноог Монгол Улсын дээд боловсролын байгууллагад оюутан элсүүлэх элсэлтийн ерөнхий шалгалтын оноотой дүйцүүлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/-д даалгасугай.

3. Энэхүү тушаалыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Дээд боловсролын газар /С.Должин/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142111266

ОЛОН УЛСЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭГ МОНГОЛ УЛСЫН
ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭТЭЙ
ДҮЙЦҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Гадаадын шилдэг их, дээд сургуулиуд хүлээн зөвшөөрдөг Кембрижийн IGCSE/international general certificate secondary education/, AS/advanced subsidiary/ A/advanced/, O/Ordinary/ түвшний хөтөлбөр болон, IB/international baccalaureate/, AP/advanced placement/ хөтөлбөрийн үнэлгээг элсэлтийн ерөнхий шалгалт /цаашид ЭЕШ гэх/-ын үнэлгээтэй дүйцүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Үнэлгээг дүйцүүлэхдээ олон улсад нийтлэг хэрэглэдэг оноо шилжүүлэх аргачлалыг ашиглана.

1.3. Олон улсын хөтөлбөрөөр хичээллэн ерөнхий боловсролын сургууль төгсөгч нь олон улсын шалгалтын үнэлгээгээ элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээнд дүйцүүлэх, эсвэл элсэлтийн ерөнхий шалгалтад хамрагдаж үнэлүүлэхийн аль нэгийг сонгоно.

Хоёр. Үнэлгээг дүйцүүлэх хүрээ

2.1. IGCSE түвшний хөтөлбөрүүдийн олон улсын шалгалтад авсан үнэлгээг дараах хичээлийн Элсэлтийн ерөнхий шалгалт /цаашид ЭЕШ гэх/-ын үнэлгээнд дүйцүүлнэ. Үүнд:

№	IGCSE	ЭЕШ
1	English 0500, 0511, 0524, 0522, 0486, 0427, 0476, 0510 хөтөлбөр	Англи хэл
2	Mathematics 0580, 0606, 0459, 0607, 0444, 0581 хөтөлбөр	Математик
3	Physics 0625, 0443 хөтөлбөр	Физик
4	Chemistry 0620, 0439 хөтөлбөр	Хими
5	Biology 0610, 0438, хөтөлбөр	Биологи
6	Russian 0516 хөтөлбөр	Орос хэл
7	Geography 0460, 0457, 0426 хөтөлбөр	Газарзүй
8	Coordinated Science 0654, 0442 хөтөлбөр	Хими, Физик, Биологи-ийн сонгосон 2

2.2. Кембрижийн O түвшний хөтөлбөрийн олон улсын шалгалтын үнэлгээг дараах хичээлүүдийн ЭЕШ-ын үнэлгээнд дүйцүүлнэ. Үүнд:

№	Кембрижийн O түвшин	ЭЕШ
1	English 1123, 2010 хөтөлбөр	Англи хэл
2	Mathematics 4037, 4024 хөтөлбөр	Математик
3	Physics 5054 хөтөлбөр	Физик
4	Chemistry 5070 хөтөлбөр	Хими
5	Biology 5090 хөтөлбөр	Биологи
6	Russian хөтөлбөр	Орос хэл
7	Geography 2217 хөтөлбөр	Газарзүй

2.3. Кембрижийн А түвшний хөтөлбөрийн олон улсын шалгалтын үнэлгээг дараах хичээлүүдийн ЭЕШ-ын үнэлгээнд дүйцүүлнэ. Үүнд:

	Кембрижийн AS, А түвшин	ЭЕШ
1	English 8693, 8287, 9093, 9695, 9276 хөтөлбөр	Англи хэл
2	Mathematics 9709, 9231, 9280 хөтөлбөр	Математик
3	Physics 9277, 9702 хөтөлбөр	Физик
4	Chemistry 9701, 9185 хөтөлбөр	Хими
5	Biology 9700, 9184 хөтөлбөр	Биологи
6	Geography 9696, 9278, 8987, 8275 хөтөлбөр	Газарзүй
7	Coordinated Science хөтөлбөр	Хими, Физик, Биологи-ийн сонгосон 2

2.4. IB хөтөлбөрийн олон улсын шалгалтын үнэлгээг дараах хичээлүүдийн ЭЕШ-ын үнэлгээнд дүйцүүлнэ. Үүнд:

	IB	ЭЕШ
1	English SL, HL	Англи хэл
2	Mathematics SL, HL	Математик
3	Physics SL, HL	Физик
4	Chemistry SL, HL	Хими
5	Biology SL, HL	Биологи
6	Russian SL, HL	Орос хэл
7	Geography SL, HL	Газарзүй

2.5. AP хөтөлбөрийн олон улсын шалгалтын үнэлгээг дараах хичээлүүдийн ЭЕШ-ын үнэлгээнд дүйцүүлнэ. Үүнд:

	AP	ЭЕШ
1	AP English Language and composition, AP English Literature and composition	Англи хэл
2	AP Calculus AB, BC, AP statistics	Математик
3	AP Physics B, C and Mechanics	Физик
4	AP Chemistry	Хими
5	AP Biology	Биологи
6	AP Human Geography	Газарзүй

Гурав. Үнэлгээ дүйцүүлэхэд тавигдах шаардлага

3.1. Дүн дүйцүүлэх хүсэлт гаргаж буй сурагч нь ерөнхий боловсролын сургалтыг дүүргэснээ нотлох баримт бичигтэй байна.

3.2. Олон улсын шалгалтад хамрагдаж авсан үнэлгээ нь сертификатаар баталгаажсан байна.

3.3. Дүйцүүлсэн хэмжээст оноо нь ЭЕШ-аас өөр зориулалтаар ашиглагдахгүй.

Дөрөв. Үнэлгээ дүнг дүйцүүлэх ажлыг зохион байгуулах

4.1. Олон улсын шалгалтын үнэлгээг ЭЕШ-ийн хэмжээст оноонд дүйцүүлэх ажлыг Боловсролын үнэлгээний төв хариуцан гүйцэтгэнэ.

4.2. Олон улсын хөтөлбөрөөр /Кембрижийн IGCSE, A, O болон IB, AP/ сургалтын үйл ажиллагаа явуулдаг сургуульд сурч төгссөн сурагчид олон улсын шалгалтын үнэлгээгээ ЭЕШ-ийн үнэлгээнд дүйцүүлэх саналаа Боловсролын үнэлгээний төвд өөрийн биеэр гаргана.

4.3. Үнэлгээ дүйцүүлэх хүсэлтэй иргэд Боловсролын үнэлгээний төвд хүсэлтээ гаргах ба хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан үнэлгээг дүйцүүлсэн батламж хуудсыг олгоно.

4.3.1. Суралцагчийн бүрдүүлэх материал

- Үнэлгээ дүйцүүлэх тухай хүсэлт/сурагч, эцэг эх асран хамгаалагчдын гарын үсэг иргэний бичиг баримтын хуулбараар баталгаажсан/.
- Төрсний гэрчилгээ эсвэл иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
- IGCSE certificate - сертификат
- IGCSE statement of results – дүнгийн хуудас
- Эсвэл Certifying statement /Кембрижийн сертификатуудыг хуулбарлах, нотариатаар баталгаажуулахыг хориглодог зөвхөн Кембрижийн өөрийн гаргасан энэ тодорхойлолтыг хүчин төгөлдөр гэж үздэг/
- Statement of registration /сурагчийн регистрийн дугаартай/
- Бүрэн дунд боловсролын үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Тухайн сургуулийг сурч төгссөн тухай сургуулийн тодорхойлолт

4.4. Суралцагчдын дүйцсэн оноог ЭЕШ-ын үндсэн жагсаалтад оруулахгүй ба харгалзах хичээлийн жагсаалтад онооны дагуу байршуулж тусад нь жагсаалт үүсгэж Боловсролын үнэлгээний төвөөс дээд боловсролын сургалтын байгууллагад мэдэгдэнэ.

4.5. Хүсэлт гаргасан суралцагчдын дүйцсэн үнэлгээг баталгаажуулсан “Батламж хуудас”-ыг Боловсролын үнэлгээний төвөөс олгоно.

4.6. Суралцагч нь дүйцүүлсэн онооны Батламж хуудсаар Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцах эрхтэй.

Тав. Үнэлгээг дүйцүүлэх аргачлал

5.1. Олон улсын шалгалтад хамрагдаж авсан үнэлгээг баталгаажуулах сертификат нь дүйцүүлэх үнэлгээний үндсэн баримт бичиг болно.

5.1.1. Кембрижийн олон улсын шалгалтын үнэлгээг (IGCSE, O, AS, A) ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэхэд суралцагчдын олон улсын шалгалтын дүнгийн хуудсан дээр тоон (percentage uniform mark) болон үсгэн хэлбэрээр бичигддэг үнэлгээг дүйцүүлэхэд ашиглана.

5.1.1.1. Кембрижийн олон улсын шалгалтын үнэлгээг ЭЕШ-ын үнэлгээтэй дараах утгуудад харгалзуулан тооцно.

IGCSE, O, түвшин	A*	A	B	C	D	E	F	G
ЭЕШ	A-	A-	B	B	C	C	D	D

AS түвшин	a	b	c	d	e
ЭЕШ	A	A-	B	B-	C

A түвшин	A*	A	B	C	D	E
ЭЕШ	A	A	A-	B	B-	C

5.1.2. IB-ийн үнэлгээг ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэхэд

IB	7	6	5	4	3	2	1
ЭЕШ	A	A	A-	A-	B	C	D

5.1.3. AP-ийн үнэлгээг ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэхэд

AP	5	4	3	2	1
ЭЕШ	A	A	A-	B	C

5.1.4 TOEFL болон IELTS шалгалтын үнэлгээг ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэхэд /оноогоор/

ЭЕШ	A	A-	B	B-	C	C-	D	D-
TOEFL	90	80	70	60	50	40	30	20
IELTS	7	6.5	6	5.5	5	4.5	4	3.5

5.1.5 SAT-ийн үнэлгээг ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэхэд

ЭЕШ	A	A-	B	B-	C	C-	D	D-
SAT	650	600	550	500	450	400	400<	400<

5.1.4 Их, дээд сургуулийн элсэлтийн шалгалт нь бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалттай нэгдмэл авдаг гадаадын ахлах сургууль төгссөн болон энэ журмын 1.1-д зааснаас бусад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрөөр суралцаж төгссөн окутан, суралцагчдын сурлагын дүн, оноог монгол улсын элсэлтийн ерөнхий шалгалтын дүн, оноонд дүйцүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

ЭЕШ	A	A-	B	B-	C	C-	D	D-
Үсгэн үнэлгээтэй дүйцүүлбэл	A	A	B	B	C	C	D	D

ЭЕШ	A	A-	B	B-	C	C-	D	D-
Гүйцэтгэлийн хувиар дүйцүүлбэл	90-100%	80-89%	70-79%	60-69%	50-59%	40-49%	30-39%	20-29%

ЭЕШ	A	A-	B	B-	C	C-	D	D-
Тоон үзүүлэлтээр дүйцүүлбэл	5	4.5	4	3.5	3	2.5	2	1.5

5.2. Олон улсын шалгалтад авсан үнэлгээг Элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээтэй дүйцүүлэхдээ хэмжээст оноо /СЕЕВ/, амжилтын чанарын индексээр тооцож гаргана.

5.3. Олон улсын шалгалтын үнэлгээг ЭЕШ-ийн тухайн жилийн хичээл тус бүрийн амжилтын чанарын индексийн тархалтын мужид шилжүүлэн тухайн харгалзах мужийн дээд хэмжээгээр нь тооцож гаргана.

Зургаа. Бусад зүйл.

6.1. Тухайн хөтөлбөрүүдээр дотоод болон гадаадын ерөнхий боловсролын сургуульд суралцаж төгссөн оюутан, суралцагчид хамрагдах боломжтой.
